



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ, ҮР ДҮН



**ТУШААЛ, ШИЙДВЭРҮҮД НЬ ХУУЛЬ ЗӨРЧСӨН, ЭРХ ЗҮЙН ХУВЬД
ЗӨРЧИЛТЭЙ ГАРЧ БАЙНА.**

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

ААГ-ын Гүйцэтгэлийн аудитын баг

Газрын дарга, тэргүүлэх
аудитор

Ч.Чүлтэмбат

Аудитын менежер

Ш.Мөнхбаяр

Ахлах аудитор

Ш.Ганчимэг

Аудитор

Ч.Гантулга

Д.Отгонбаяр

Н.Отгонцэцэг

2018 оны 06 дугаар сар

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
7037-3089, 7037-8142 дугаарын
утсаар харилцана уу.

ХАЯГ:

Төрийн аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр
Дархан-Уул аймаг

Товчилсон үгийн жагсаалт	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5

Бүлэг 1 Байгууллагын зорилтын хэрэгжилт төлөвлөсөн үр дүнд хүрчээ.

- 1.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.....6-10
- 1.2. Албан хаагчдын хувийн хэргийн материалыг зохих журмын дагуу бүрдүүлжээ..... 11
- 1.3. Тушаал шийдвэрүүд нь хууль зөрчсөн, эрх зүйн хувьд зөрчилтэй гарч байна..... 12

Бүлэг 2 Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.

- 2.1.13
- 2.2. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, үр ашиг, хөрөнгийг бэлтгэсэн байдал хууль журмын дагуу байна 14
- 2.3. 14

Бүлэг 3 Татварын хяналт шалгалтын чанар, үр дүн хангалтгүй байна.

- 3.1. Хяналт шалгалтын төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлжээ.....
- 3.2. Хяналт шалгалтаар ногдуулсан татвар өмнөх оныхоос 53.5 хувиар буурчээ..... 15
- 3.3. 16

Дүгнэлт, зөвлөмж.....17

Товчилсон үгийн жагсаалт

АЗДТГ	Аймгийн Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ТЕГ	Татварын ерөнхий газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
УИХ	Улсын их хурал
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ЦХТАОАТ	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар
ОАТ	Орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТУАБ	Татварын улсын ахлах байцаагч
ТУБ	Татварын улсын байцаагч
ТБМНС	Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан
БМТТХТ	Бэлэн мөнгөний татвар, торгууль хураах тасалбар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
АБ	Ажлын баримт

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудитын нэр:

Татварын хэлтсийн үйл ажиллагаагаа, үр дүн

2. Аудитын код:

ДАА-ТАГ/2018/02-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Аудитын төлөвлөгөө, сэдэв батлах тухай” 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/06 дугаар тушаал, аймгийн ИТХ-ын захиалга, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аудитын стандарт, журмын дагуу хийлээ.

4. Аудитын зорилт:

Татварын хэлтсийн үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж байгаа эсэхэд гүйцэтгэлийн аудит хийж, дүнг аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах асуудлуудад аудитыг чиглүүлэв.

- Байгууллагын чиг үүрэг, дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил, түүний хэрэгжилт, төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх
- Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлт, үр ашигтай, хууль, журмын дагуу зарцуулсан эсэх
- Дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагаа үр дүн, үр нөлөөтэй байгаа эсэх

5. Хамарсан хүрээ:

Аудитад аймгийн Татварын хэлтсийн 2016, 2017 оны санхүү, төсвийн орлогын бүрдүүлэлтийн болон дотоод хяналтын талаарх баримт материал, ГХБХБГ, Хонгор сумын газрын даамал, Захирагчийн алба, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, зарим аж ахуйн нэгж байгууллагын мэдээ, тайлангууд хамрагдав.

6. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.
Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
 - Татварын ерөнхий хууль
 - ААНОАТ-ын тухай хууль
 - Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
-

- НББ-ийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- УИХ, ЗГ, ТЕГ-ын тогтоол, журам, заавар, болон дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, дүрэм, журам
- ТЕГ-ын болон байгууллагын дотоод журам

7. Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, аудитын хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглав. Үүнд:

- ✓ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100),
- ✓ Гүйцэтгэлийн аудитын журам, арга зүй
- ✓ Татварын хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг судлах
- ✓ Тус газрын санхүүгийн тайлан тэнцэлд дүн шинжилгээ хийх
- ✓ Түүвэрлэлтийн арга зүйг ашиглав.
- ✓ Холбогдох албан тушаалтантай ярилцаж, тодруулга, лавлагаа авах, тоон мэдээлэл гаргуулан судалгаа хийх, төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлийг үнэлэх
- ✓ Аудитын хөтөлбөр, горимын дагуу цуглуулсан баримт, материал, нотлох зүйлд дүн шинжилгээ хийх, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалгах, мэдээллийн эх үүсвэртэй тулган баталгаажуулах зэрэг арга зүйг ашиглав.

Аудитыг УАГ-ын харьяа Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Чүлтэмбат удирдаж, чанарын хяналтыг аудитын менежер Ш.Мөнхбаяр хэрэгжүүлэн, ахлах аудитор Ш.Ганчимэг, аудитор Ч.Гантулга, Д.Отгонбаяр, Н.Отгонцэцэг нар хийв.

8. Аудит хийсэн хугацаа:

Аудитыг 2018 оны 4 дүгээр сарын 09-нд эхэлж, 6 дугаар сарын 15-нд дуусгав.

Аудитын явцад хамтран ажиллаж, шаардлагатай баримт бичгийг хугацаанд нь гаргаж өгч, хамтран ажилласан захиргааны тасгийн дарга, ТАУБ Б.Сэлэнгэ, татварын орлогын бүртгэл хариуцсан татварын улсын байцаагч С.Алтантуяа, нягтлан бодогч О.Алтантуяа нарт талархал илэрхийлье.

БҮЛЭГ 1

БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ
ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЧЭЭ

Нэг. Аудитын дүн

1.1 Зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүн

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

1.1.1 Дархан-Уул аймгийн Татварын хэлтэс татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, улс болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. Түүнчлэн үйл ажиллагааны үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт заасан зорилт, чиглэлүүдийг удирдлага болгон ажиллаж иржээ. Үндсэн зорилгоо хангахын тулд 2017 онд дараах ажлыг зохион байгуулсан байна.

“Бүртгэлийг сайжруулах” зорилтын хүрээнд татвар төлөгчдийн сүүлийн 5 жилийн бүртгэлд судалгаа хийж татварын төрлөөр давхар бүртгэгдсэн бүртгэлийг залруулж, баазад бүртгэлтэй иргэн, хуулийн этгээд байгууллагыг нэг бүрчлэн шалгах зэргээр бүртгэл мэдээллийн сангийн үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллажээ. Үүнд 361 ААНБ-ыг шинээр нэмж бүртгэсэн ба үйл ажиллагаа эрхлээгүй, шилжсэн 89 ААНБ-г татвар төлөгчийн бүртгэлээс хасаж, 135 ААНБ-ын бүртгэлд нэмэлт өөрчлөлт хийсэн байна. Мөн 1046 иргэнд татвар төлөгчийн цэнхэр дэвтэр олгож, татварын байр суурийг 4013 татвар төлөгч иргэнээр нэмэгдүүлжээ. НӨАТ-ын тухай хуулийн дагуу 44 татвар төлөгчийг нэмж бүртгэн, үйл ажиллагаа эхлээгүй болон босго хүрээгүй 75 татвар төлөгчийг НӨАТ суутган төлөгчөөс хассан байна.

Татварын албаны үйлчилгээний стандартыг үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлж ТЕГ-ын өр дуудах төвтэй хамтран 58 татвар төлөгчийн 11,8 сая төгрөгийг барагдуулсан байна.

ААНОАТ-ын тайлангийн ирц 74,62, ЦХТАОАТ-ын тайлангийн ирц 75,62, НӨАТ-ын ирц 95,2, бусад тайланг 100 хувь тус тус хүлээн авч баталгаажуулжээ.

Татварын тайланг төрөл бүрээр шалгаж, шалгуур хангаагүй 124 татвар төлөгчийн 2185,8 сая төгрөгийн зөрчилд 209,0 сая төгрөгийн татвар нөхөн ногдуулсан байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг Шилэн дансны тухай хуулиар хэрэгжүүлж ажиллажээ.

Төсвийн орлогын төлөвлөгөөг үндэслэл муутай боловсруулжээ.

1.1.2 Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар баталсан Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Дархан-Уул аймгийн орон нутгийн суурь орлогыг 15,192.4 сая төгрөгөөр баталсныг аймгийн ИТХ 3,430.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 18,622.7 сая төгрөгөөр баталжээ. Аймгийн ИТХ 2017 онд орон нутгийн төсөвт 4 удаа тодотгол хийж, орон нутгийн нийт орлогыг 3,048.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 21,671,4 сая төгрөгөөр баталсан байна.

Эдийн засгийн төлөв байдалд тулгуурлан 2017 оны төсвийн орлогын төлөвлөгөөг төсвийн тэнцвэртэй байдлыг баримтлах, орон нутгийн хэмжээнд татвар, төлбөр хураамжийн тогтвортой орчныг хангах, хүчин төгөлдөр мөрдөж буй татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах зарчмыг баримтлан татварын орлогыг нэмэгдүүлж баталжээ. Үүнд орон нутгийн төсвийн орлогыг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас хуулиар олгогдсон зарим татварын хувь хэмжээг өсгөж тогтоосон ИТХ-ын тогтоол болон төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг үндэслэн нэмэлт эх үүсвэрийг бий болгосон байна. Төсвийн тодотголоор цалин хөлс, түүнтэй адилтгах ОАТ 1,386.9 сая, хөрөнгө борлуулсны ОАТ-ыг 155.5 сая, татварын орлогын бусад орлогыг /суутган-4/ 683.0 сая, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 241.8 сая, улсын тэмдэгтийн хураамжийг 51.5 сая, газрын дуудлага худалдааны орлогыг 318.0 сая, байгалийн нөөц ашигласны төлбөрийг 108.4 сая, хүү, торгуулийн орлогыг 100.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ. Орон нутгийн төсвийн орлого 2012 оноос хойш 7,811.2 сая төгрөгөөр буюу 55 хувиар нэмэгдэж байгаа боловч тухайн жилд тодотгох үндэслэл нь төсвийн орлогын төлөвлөлттэй бус, хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зарлагатай уялдуулж нэмэгдүүлдэг байна. Орон нутгийн төсвийг баталсан тодотголуудаас 5, 12 дугаар саруудад хийсэн тодотгол нь “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-тай холбогдуулан тодотгожээ.

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа өмнөх оны гүйцэтгэл, татварын өрийн үлдэгдлийг үндэслэдэг гэсэн тайлбар өгдөг ч татварын орлогын гүйцэтгэлийн тайлан, өрийн үлдэгдлийг үндэслэн тооцож үзэхэд 2017 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэх боломж байсан байна. 2016 оны татварын ногдуулалт 25,962.4 сая, оны эхний татварын өрийн дутуу 8,309.7 сая, илүү 5,080.0 сая, хүлээгдэж буй гүйцэтгэлээр барагдуулалт 23,630.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байхад 2017 онд орлогыг 18,622.7 сая төгрөгөөр баталжээ. Энэ нь орон нутгийн татварын орлогыг үндэслэл муутай боловсруулсныг харуулж байгаа ба үүнийг 4 удаагийн төсвийн тодотгол ч баталж байна.

Орон нутгийн татварын орлогын 22,420.1 сая төгрөгийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгагдсан орлогын дүнтэй тулган шалгахад 1,643.1 сая төгрөгөөр зөрсөн нь хувь хүний орлогын албан татварын буцаалт байна. Хувь хүний орлогын татварын орлого нийт дүнгээс буцаан олголтын дүнг хассан дүнгээр нэгдсэн тайланд тусгагджээ. Хадгаламжийн хүүгийн орлого 747,8 сая төгрөгийг татварын бус орлогын бусад татварт оруулж тайлагнасан

байна. Цаашид хадгаламжийн хүүгийн орлогыг хувь хүний орлогын албан татварын ангилалд тусгаж тайлагнах нь зүйтэй байна.

Татварын орлогын гүйцэтгэл, хураалтын үйл ажиллагаа хууль, журмын дагуу явагдаж байна.

1.1.3 Орон нутгийн татварын орлогын биелэлт 2017 онд 21,254.3 сая төгрөгт хүрч төлөвлөгөөг 531.3 сая төгрөгөөр буюу 2,5 хувиар, өмнөх оны гүйцэтгэлээс 2,723.6 сая төгрөгөөр буюу 14,0 хувиар давж биелүүлсэн байна.

Татварын орлогын гүйцэтгэлд судалгаа хийхэд цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 161.4 сая, бусад орлого 71.4 сая, газрын дуудлага худалдаа 59.4 сая, хүү, торгуулийн орлого 186.7 сая, ус рашааны нөөц ашигласны төлбөр 128.6 сая төгрөгөөр тус тус давсан бол үл хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 69.1 сая, галт зэвсийн албан татвар 11.7 сая, улсын тэмдэгтийн хураамж 85.6 сая, байгалийн ургамал ашигласны төлбөр 1.2 сая төгрөгөөр тус тус тасарчээ. Үүнд татварын тайлан суутган 1-ийн ирц хангалтгүй, улс орны эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас ипотекийн зээлийн хэмжээ буурснаас хөрөнгийн борлуулалт багассан нь нөлөөлжээ. Түүнчлэн өмнөх оны гүйцэтгэлээс улсын тэмдэгтийн хураамж 104.9 сая, галт зэвсгийн албан татвар 2.1 сая, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 11.9 сая төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй байгаа бөгөөд үүнд улсын тэмдэгтийн хураамжийн төрлөөр татвар төлөгчийн тайланд хяналт тавьдаггүй, галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл эзэмшигчид татварт бүрэн хамрагддаггүйгээс шалтгаалсан байв.

Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг 2016, 2017 оны байдлаар улс, аймаг, сумын татварын орлогын биелэлт, жигд ажиллагааны түвшин гэсэн үзүүлэлтээр харуулбал:

1.Төлөвлөгөөний биелэлт	2016 он			2017 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Улсын төсөв	4,018.30	4,625.80	115.12	6,289.8	7,916.7	125.87
Аймгийн төсөв	17,700.90	18,249.50	103.1	19,223.2	19,873.0	103.38
Сумдын төсөв	2,001.30	2,214.10	110.63	2,690.3	2,547.2	94.68
Нийт дүн	23,720.50	25,089.40	105.77	28,203.3	30,336.9	107.57
2.Жигд ажиллагааны түвшин	Биелсэн /сарын тоо/	Биелээгүй /сарын тоо/		Биелсэн /сарын тоо/	Биелээгүй /сарын тоо/	
Улсын төсөв	7	5	71.429	9	3	33.33
Аймгийн төсөв	6	6	100	7	5	71.43
Сумдын төсөв	8	4	50	4	8	200.00
Нийт дүн				20	16	80.00

Хүснэгтээс харахад 2017 онд улс, аймгийн төсвийг давуулан биелүүлсэн бол сумын төсвийг 5.3 хувиар тасалсан, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 99,05 хувиар биелүүлсэн байна. Аймгийн төсвийг 7 сар биелүүлж, 5 сард нь тасалсан бол сумын төсвийг 8 сар тасалсан байна.

Татвар хураалтын үйл ажиллагаанд шат дараалсан арга хэмжээ авч, алданги торгууль, хүү тооцож ажилласан байна.

1.1.4 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн нутаг дэвсгэрийн байршил, үйл ажиллагааны хамрах хүрээг харгалзан сум, 16 баг, болгон улсын байцаагч нарт хуваарилжээ. Үүнээс төсөвт байгууллага, том аж ахуйн нэгжүүдийг 1 байцаагчид хуваарилсан ба татвар төлөгчдийг бүртгэлд хамруулах, орлого бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хариуцуулж, тэдгээрт хууль тогтоомжийг сурталчлах, үйлчилгээ үзүүлэх зэргээр улс, орон нутгийн татварын орлогын биелэлтийг хэрэгжүүлж байна.

Татвар төлөгчдөөс төвлөрүүлсэн татварын орлогыг боловсруулах, төсөвт төвлөрүүлэх, орлогын мэдээ гаргаж тогтмол мэдээллээр хангах, татвар төлөгчийн тайлан, хяналт шалгалтаар ногдуулалт хийж, харилцах дансны хуулганы дүнг тулган шалгаж, хяналт тавьж ажиллаж байна. Татварын орлогыг үнэн зөв бүртгэж, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд нэгтгүүлэн орлогын гүйцэтгэлийн мэдээг сар бүр ТЕГ болон аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй тооцоо нийлж, баталгаажуулдаг. Түүнчлэн төрийн сан татвар төлөгчийн ирүүлсэн хүсэлтийг үндэслэсэн албан бичгийг үндэслэн залруулгыг хийж байна. Татварын тайлан, хяналт шалгалтын актаар тайлант оны татварыг ногдуулахын зэрэгцээ хөндлөнгийн мэдээллийг ашиглаж төлбөр ногдуулж байна.

Татварын ногдуулалт, барагдуулалтыг 2016, 2017 оны байдлаар харуулбал:

Он	Оны эхэнд		Тайлант хугацаанд		Дансаар	Татвар хооронд		Буцаан олгосон	Оны эцэст	
	Дутуу	Илүү	огдсон	Буцаан олгох		Дутуу -г	Илүү-с		Дутуу	Илүү
2016	8,962.2	5,188.0	26,683.2	2,717.8	23,882.7	889.3	889.3	1,823.9	10,142.4	4,739.8
2017	10,142.4	4,739.8	34,884.3	3,844.1	29,221.9	686.3	686.3	1,654.1	13,928.8	5,094.1

Татварын хэлтсийн 2016 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын татвар ногдуулалтаар 26,683.2 сая төгрөг, дансаар 23,882.7 сая төгрөгийн татвар төлөгдсөн ба үүнд өмнөх оны татварын дутуу /өр/ 5,728.2 сая төгрөг орсон байна. Зөрүү 18154,5 сая төгрөг нь зөвхөн тайлант оны ногдуулалтын барагдуулалтад тооцогдох юм. Өөрөөр хэлбэл тухайн оны гүйцэтгэлд өмнөх оны татварын өглөг төлөгдөж байгаа болно. Татварын илүү төлөлт 2016 оны эцэст 448.3 сая төгрөгөөр буурсан, 2017 онд 354,3 сая төгрөгөөр өссөн нь татвар хооронд илүүгээс дутуу руу шилжүүлсэн болон илүү төлөлттэй холбоотой байна. Татварын илүү төлөлт ихээхэн өндөр дүнтэй гарсан нь зарим, аж ахуйн нэгж, иргэд тухайн оны татварын тайланг ирүүлээгүйгээс ногдуулалт ороогүй нь шалтгаалжээ. Тухайлбал: “Анод банк”, “Зарубежстрой в Монголий”, “Цагаан нуур Арцат” ХХК, “Тэгш цацрал” зэрэг ХХК-д байна. Аудитын явцад орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг 2017 оны 3,6,9,12 сарыг сонгон харилцах дансны хуулга, бусад баримттай тулган шалгахад дансаар орсон мөнгөн дүн, байгууллага хоорондын тооцоогоор суутган тооцсон болон залруулсан дүнгүүд таарч байна. /Ажлын баримт 1,2,3,4-с үзнэ үү/

2017 оны жилийн эцсийн татварын тооцоолол баталгаажуулаагүй байна.

1.1.5 2017 оны жилийн эцсийн татварын тооцооллын үлдэгдлийг хэлтсийн даргын тушаалаар баталгаажуулаагүй байгаа тул ТБМНС-аас татварын тооцооллын товчоог авч үзэхэд татварын тайлангаар 13,484.0 сая, татварын хяналт шалгалтаар 445.7 сая нийт 13,929.7 сая төгрөгийн өр бүртгэгдсэн байна.

Нийт өрийн 9,906.1 сая төгрөг буюу 71.1 хувь нь тайлант оных бол 4,023.6 сая буюу 28.9 хувь нь өмнөх оны өр байна. Татварын хэлтсийн даргын 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар баталгаажуулсан дүнг 2016 оны жилийн эцсийн 10,279.2 сая төгрөгийн татварын ТБМНС-рх өрийн бүртгэлтэй тулган шалгахад 138.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
/сая.төг/

Үзүүлэлт	Хэлтсийн даргын тушаал			ТБМНС-д бүртгэлтэй өрийн дүн	Зөрүү /3-5/
	2017.05.02-ны А/14	2017.07.20-ны А/29	Зөрүү		
1	2	3	4	5	6
2016 оны жилийн эцсийн өр	10,279.2	10,281.9	-2.7	10,140.9	140.9

Хэлтсийн даргын 2017 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/29 тоот тушаалаар 2016 оны татварын өрийг 10,281.9 сая төгрөгөөр өөрчилж баталгаажуулсан бөгөөд өмнөх тушаалын дүнгээс 2,7 сая төгрөгөөр илүү байна. Өөрөөр хэлбэл: ТБМНС-д бүртгэлтэй татварын өр уг тушаалаар баталгаажуулсан дүнгээс 140,9 сая төгрөгөөр дутуу байгаа зөрчил илэрч, аудитын явцад залруулуулав. Тухайлбал: “Төгсгэрэл констракшн” ХХК 2016 оны 12 дугаар сарын 31-нд 153,516.5 мянган төгрөгийн өртэй байсан боловч ТБМНС-ийн мэдээлэлд 470,070.1 мянган төгрөгийн илүү төлөлт үүссэн алдааг засварлуулан мэдээлэл үнэн зөв болсон байна.

Хөндлөнгийн мэдээлэл ашиглаж төлбөр ногдуулсан байдал хангалтгүй байна.

1.1.6 Төрийн болон бусад байгууллагуудаас хөндлөнгийн мэдээлэл цуглуулахдаа албан бичгээр хандаж, мэдээ, судалгааг тогтмол авах талаар харилцан мэдээлэл солилцох гэрээ байгуулж ажиллаж байна. Хөндлөнгийн мэдээллийг шалгаж, ногдуулсан төлбөрийн дүн нь хөндлөнгийн мэдээлэл ашиглаж илрүүлсэн зөрчлийн 13 хувь байхаар шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдаг байна. Тайлант онд 84,560.8 сая төгрөгийн хөндлөнгийн мэдээлэл ашиглан илрүүлсэн 2,078.2 сая төгрөгийн зөрчилд 204,9 сая төгрөгийн татвар ногдуулсан нь илрүүлсэн зөрчлийн 9.9 хувь буюу шалгуур үзүүлэлтийг хангаагүй гэж ТЕГ-ын дотоод хяналт шалгалтаар дүгнэгдсэн байна.

Аудитын явцад тус хэлтсийн ТБМНС-д суутган-1 татварын тайлангаар татвар суутгаагүй орлого олсон татвар төлөгч иргэдийн жагсаалтаас 13 татвар төлөгчийн татварын барагдуулалтыг түүвэрлэн шалгахад 3 иргэний орлогын мэдээллийг холбогдох газруудад шилжүүлсэн, 5 иргэн төлсөн, 3 иргэн тайлан өгөөгүй, “Дархан-Ус суваг” ХК-д бараа, ажил үйлчилгээ нийлүүлсэн 2 иргэний регистрийн дугаар зөрснийг залруулаагүй, “Түмэн буудай” ХХК-аас олсон 1 иргэний 183.4 сая төгрөгийн орлогод ногдуулсан 2.1 сая төгрөгийн татвар одоо болтол барагдаагүй байна. Түүнчлэн “Минж

проперти” ХХК-нд 2018 оны 05 дугаар сарын 07-нд 368 дугаар албан бичиг хүргүүлж 2016, 2017 онд барилга угсралтын ажлыг туслан гүйцэтгэсэн болон бараа материал нийлүүлсэн 31 аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн баримт материалыг /харилцагчийн гүйлгээ/ авч тулган шалгаж 30 харилцагчийн 4,068.6 сая төгрөгийн орлогыг ТБМНС-ын баазад бүртгүүлэв. Уг мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу боловсруулж, татварын хяналт шалгалтад ашиглан татвар ногдуулахаар албан шаардлага хүргүүлээ.

Албан хаагчдын хувийн хэргийн материалыг зохих журмын дагуу бүрдүүлжээ.

1.2 Хүний нөөцийн бодлого, орон тооны бүтэц, боловсон хүчний хувьд хэлтсийн даргын 2017 оны 01 сарын 11-ны өдрийн А/01 тоот тушаалаар баталсан орон тооны хүрээнд татвар төлөгчтэй харилцах тасаг 7, татварын орлогын тасаг 21, татварын хяналт шалгалтын тасаг 9, эрсдэл, статистикийн тасаг 4, захиргааны тасаг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр нийт 50 орон тоотой ажиллажээ. 2017 онд Хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч 1, тасгийн дарга, ТУАБ 5, ТУБ 27, татвар хураагч 6, гэрээт ажилтан түр орлон гүйцэтгэгч 5, үйлчилгээний ажилтан 6 буюу орон тооны 50, орон тооны бус байцаагч 6 ажилтан гэрээгээр ажиллаж байна. Захиргааны тасаг нь тасгийн дарга, хуулийн зөвлөх, нягтлан бодогч архив, бичиг хэргийн ажилтан-нярав, жолооч, сантехникч-цахилгаанчин, үйлчлэгч /2/ гэсэн 8 орон тоотой ажиллаж байна. Хүний нөөцийн, архивын ажилтан байхгүй учир тасгийн дарга хүний нөөцийн, нягтлан бодогч архивын ажлыг тус тус хариуцсан гүйцэтгэж байна.

УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын 3 дахь заалтаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Гааль, ТЕГ татан буугдсантай холбогдуулан ТЕГ-ын даргын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Б/192 тоот тушаалаар тус хэлтсийн 47 ажилтан, албан хаагчдыг үүрэгт ажлаас чөлөөлж, мөн өдрөөс 48 ажилтан, албан хаагчдыг ажил, албан тушаалд нь томилохдоо татварын хяналт шалгалтын тасагт улсын байцаагчаар Ж.Алтанзулыг нэмж томилсон байв. Боловсон хүчний чадавхын хувьд тус хэлтэст бакалаврын зэрэгтэй 36, магистрын зэрэгтэй 10 ажилтан байна. Мөн мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй болон хугацаатай эрх авсан 17 ажилтан байгаа бөгөөд 1-5 жил ажилласан 28, 5-10 жил ажилласан 9, 10-15 жил ажилласан 8 ажилтан, 15-с дээш жил ажилласан 3 ажилтан байна. Хүний нөөцийн хувийн хэргийн бүрдлийн талаар үзэхэд шаардлагатай баримт материалыг жагсаалтын дагуу бүрдүүлсэн байна. Цаашид төрийн албан хаагч бүр өөрийн хувийн хэргийн бүрдлийг хангаж, хүний нөөцийн ажилтан нягтлан шалгаж баяжилтыг тогтмол хийлгүүлж байх үүрэгтэй.

Тушаал, шийдвэрүүд нь хууль зөрчсөн, эрх зүйн хувьд зөрчилтэй гарч байна.

1.3 ТЕГ-ын даргын 2016 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн аймгийн Татварын хэлтсийн даргын 2016 оны А/35 дугаар тушаалаар хэлтсийн хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдсөн байна. Зарим улсын байцаагч, төрийн болон үйлчилгээний албан хаагчдыг хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч тушаалаар томилж байгаа нь ТЕГ-ын даргын

шилжүүлсэн бүрэн эрхийг зөрчсөн байна. Хөдөлмөрийн дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.6-д “Албан хаагчид 4 өдөр болон түүнээс дээш 3 хүртэлх сарын хугацаатай чөлөөг цалинтай болон цалингүй олгох асуудлыг Татварын ерөнхий газрын дарга шийдвэрлэнэ” гэж ТЕГ-ын дотоод журамд заасныг хэлтсийн даргын 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/08 тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 6 дугаар зүйл 6.9 дэх заалт буюу “Албан хаагчид 4 болон түүнээс дээш 3 хүртэлх сарын хугацаатай чөлөөг цалинтай болон цалингүй олгох асуудлыг Татварын хэлтсийн дарга шийдвэрлэнэ” гэж тусгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Ажил олгогч нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх...”, мөн хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д “ Ажил олгогч нь ажилтанд түүний хүсэлтээр чөлөө олгож болно.” 80.2-т “Чөлөөтэй байгаа хугацаанд тэтгэмж олгох, эсэх асуудлыг хамтын ба хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд зааснаар зохицуулна” гэж заасантай нийцэхгүй байна. ТЕГ ажил олгогчийн хувьд дотоод журамд заасны дагуу 4 болон түүнээс дээш 3 хүртэлх сарын цалинтай болон цалингүй чөлөө олгох асуудлыг ТЕГ-ын даргын тушаалаар шийдвэрлэнэ гэж заасныг хэрэгжүүлэх үүрэгтэй. Гэтэл 2016 онд Солонгос улсад эмчилгээ хийлгэх хүсэлт гаргасан 3 ажилтанд 1-2 сарын цалинтай, 2017 онд 5 ажилтанд 1-2 сарын цалингүй чөлөө олгожээ. Мөн ТУБ М.Уранчимэгт мөн дотоод журмын заалтыг үндэслэн цалинтай чөлөө олгосон байна. Иймд хэлтсийн мөрдөж буй дотоод журмыг тушаалаар хүчингүй болгож, хууль тогтоомж, журамд нийцүүлэн боловсруулж, ТЕГ-ын даргаар батлуулж мөрдөх тухай албан шаардлага хүргүүлж, Солонгос улсад зорчих, аяллын виз гаргуулсан ТУБ П.Наранчимэг, Ц.Батцэрэн, М.Уранчимэг, Б.Буянхишиг нарт цалинтай чөлөө олгосон хоногт ногдох 3,338.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

ТЕГ-ын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн Б/39 дугаар тушаалаар тус хэлтсийн ТУБ Д.Алтанзаяад Америкийн нэгдсэн улсад англи хэлний сургалтад суралцах болсонд 1 жилийн хугацаагаар төрийн албанаас түр чөлөөлж, нөөцөд бүртгэсэн боловч чөлөөний хугацаа хэтэрсэн байхад үүрэгт ажлаас чөлөөлөөгүй байв. Ер нь тушаал шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлд тавих хяналт хангалтгүй байгаа нь дээрх алдаа, зөрчлүүдээс тодорхой харагдаж байна.

БҮЛЭГ 2

**ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ
ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.**

2.1 Ажлын цаг ашиглалтын байдлыг 2016, 2017 оны сүүлийн хагас жилийн байдлаар цаг бүртгэлийн автомат төхөөрөмжийн бүртгэлээс үзэхэд албан хаагчид өдөр бүр ирсэн, явсан цагийг тогтмол бүртгүүлж хэвшсэн боловч бүртгэлийг цалин бодоход үндэслээгүй байна. Тухайлбал: М.Уранчимэг 2, Ц.Батцэрэн 1, Б.Сэлэнгэд 1 өдрийн цалин илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, Хөдөлмөрийн дотоод журмын 7.3 дахь заалтыг зөрчсөн тул нийт 170.6 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлэхээр акт тогтоолоо.

Татварын хэлтсийн даргаар ажиллаж байсан Ж.Баттулгыг ТЕГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн Б/237 дугаар тушаалаар үүрэгт ажлаас нь чөлөөлж, мөн өдрөөс хэлтсийн мэдэлд түр шилжүүлж, дараагийн албан тушаалд томилогдох хүртэл сарын үндсэн цалин, нэмэгдлүүдийг олгохыг зөвшөөрсөн байв. Ж.Баттулгад мөн өдрөөс 2017 оны 08 дугаар сарыг дуусталх хугацаанд үндсэн цалин, нэмэгдэл, хоол унааны хөнгөлөлт, үр дүнгийн урамшуулалд нийт 9,564.7 мянган төгрөг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн **23 дугаар зүйлд “Төрийн жинхэнэ албан хаагчийг захиргааны санаачилгаар албан тушаалаас нь бууруулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх”** гэсэн заалттай нийцэхгүй байна. Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, ТЕГ-ын дотоод журмын 4.9.1, 4.12 дахь заалтыг тус тус зөрчжээ. Иймд ТЕГ-ын даргын 2017 оны Б/237 дугаар тушаалын үндэслэлийг хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, эрх зүйн актуудтай нийцсэн эсэхийг Ерөнхий газрын дотоод хяналтын газраар хянуулахаар албан шаардлага хүргүүлж байна.

Тус хэлтэс 2017 оны 10 дугаар сарын 01-ээс 16 ажилтны албан тушаалын цалингийн шатлал ахиулж, төсвөөс 1,045.2 сая төгрөг зарцуулсан нь зарим ажилтны хувьд үр дүнгийн урамшуулал олгосонтой давхацсан нөгөө талаар Сангийн сайдын 2017 оны 36 дугаар тушаалын 1.1б-д Төрийн албан хаагчийн албан тушаалын зэрэглэл, шатлалыг ахиулахыг 2017 оны 05 дугаар сарын 01-ээс 2019 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэл түр зогсоох талаар харьяа төсөвт байгууллагын төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нарт үүрэг чиглэл өгснийг мөрдөөгүй тул төлбөрийн акт тогтоов.

Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, үр ашиг, хөрөнгийг бэлтгэсэн байдал хууль журмын дагуу байна.

2.2 Татварын хэлтсийн даргын 2016 оны 12 дугаар сарын 19-ны А/42 дугаар тушаалаар Хэлтсийн өмч хөрөнгийн 2016 оны жилийн эцсийн тооллогыг байна.

Тооллогоор нийт 318.2 нэр төрлийн 879,534,405 төгрөгийн үндсэн хөрөнгө тоолсон бөгөөд 5 тасгийн нийт 46 ажилтанд картаар хариуцуулсан байна.

Тус байгууллага нь хагас жилийн тооллогоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн сэргээн засварлах боломжгүй болсон хөрөнгийг 2016 оны 12 дугаар сарын 20-ны Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор актлуулахаар хүргүүлсэн хүсэлт шийдвэрлэгдэн ирсэнтэй холбоотой нийт 44 нэр төрлийн 46,133,793 төгрөгийн хөрөнгийг акталсан тул тооллогын нэгтгэл дүнгээс хасаж тооцжээ.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 55,347,125 төгрөг орлогод авч бүрэн зарцуулсан, бэлэн мөнгөний дансаар 1,358,000 төгрөг орлогод авч зориулалтын дагуу бүрэн зарцуулжээ. Нийгмийн даатгалын шимтгэл болон, ХХОАТ-ын тайлангаас түүвэрлэн шалгахад 1 сард 61, 3 сард 58, 4 сард 58, 6 сард 56, 7 сард 57, 8 сард 57, 12 сард 57 ажилчдаас тус тус шимтгэл суутган авсан байна. Шимтгэл төлсөн ажилчдын тоог тулгахад зөрүү илрээгүй ба цалингаас суутгасан дүнг цалингийн цэстэй тулган шалгахад тохирч байна.

2.3 Татварын хэлтсийн дарга аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтээр 84.3 хувь, ТЕГ-ын даргатай байгуулсан гэрээний биелэлтээр 86.9 хувийн биелэлтээр тус тус дүгнэгджээ. Нийт 47 албан хаагчийн жилийн үр дүнгийн гэрээний биелэлтээр 3 албан хаагч “В”, 44 ажилтан “А”, 2017 онд “А” авсан 31 ажилтанд тус тус үнэлэгдэж улирал бүр урамшуулал олгож иржээ.

Үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай сайн биелүүлсэн ажилтныг төрийн болон салбар, аймаг орон нутгийн шагналд уламжилж шагнуулсан байна.

2016 онд орон сууцны дэмжлэг хүссэн 1 албан хаагчийн ирүүлсэн ТЕГ-ын Төрийн захиргаа удирдлагын газарт хүргүүлж, 2017 онд гэр хороололд амьдардаг 4 албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлтөд 422.4 мянган төгрөг олгожээ.

БҮЛЭГ 3**ТАТВАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧАНАР, ҮР ДҮН
ХАНГАЛТГҮЙ БАЙНА****Хяналт шалгалтын төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлжээ.**

3.1 Байгууллагын бүтэц, орон тоо батлах тухай Татварын хэлтсийн даргын 2017 оны 01 сарын 11-ны өдрийн А/01 тоот тушаалаар татварын хяналт шалгалтын тасгийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталж өмнөх оныхоос 1 хүнээр нэмэгдүүлжээ. Тус тасаг 2017 онд хяналт шалгалтын төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, НӨАТ төлөгчийн бүртгэлээс хасагдахаар хүсэлт ирүүлсэн татвар төлөгчдийг батлагдсан хуваарийн дагуу хяналт шалгалтад 100 хувь хамруулсан байна.

Хяналт шалгалтаар ногдуулсан татвар өмнөх оныхоос 53.5 хувиар буурчээ

3.2 Татварын хяналт шалгалтаар 2017 онд 4,795.8 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 357.0 сая төгрөгийн нөхөн татвар, хүү, торгууль ногдуулан хяналт шалгалтын журмын дагуу эрсдэлийн шинжилгээ хийж Эрсдэл удирдлагын газарт хүргүүлсэн байна. Түүнчлэн 762 хөндлөнгийн мэдээлэл ашиглан 199.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж 19.3 сая төгрөгийн, гомдол, мэдээллээр 50 хүсэлт хүлээн авч 801,7 сая төгрөгийн зөрчилд 81.3 сая төгрөгийн нөхөн татвар, торгууль, хүү, алданги тус тус ногдуулжээ.

Хяналт шалгалтаар 2016 онд ногдуулсан татвар болон өмнөх оны үлдэгдлээс 17.1 хувийг, 2017 онд 25.1 хувийг дансаар барагдуулж, шүүхийн шийдвэрээр 279.8 сая төгрөгийг татварыг хүчингүй болгосон байна. ТЕГ-ын дотоод хяналтын газраас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тус хэлтсийн татварын хяналт, шалгалтын чанар, үр дүнгийн байдалд “С” үнэлгээ өгчээ. Татварын хяналт шалгалтын тасгийн улсын байцаагчийн орон тоог нэмэгдүүлсэн ч тайлант онд гүйцэтгэсэн ажлын үр дүн өмнөх оныхоос буурсан, дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дүгнэлт зэргээс үзэхэд хангалтгүй ажилласан байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Аудитаар 2016, 2017 оны үнэт цаасны тооцоог тулган шалгахад бэлэн мөнгөөр албан татвар торгууль хураасан тасалбараар 2016 онд 8743 ширхэг баримтаар 280.7 сая төгрөг, 2017 онд 9187 ширхэг баримтаар 285.0 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлж ажиллажээ. Бэлэн мөнгөөр татвар, торгууль хураах тасалбарыг санхүүгийн тайланд улсын байцаагч нарт шаардах хуудсаар олгосон дүнгээр тусгажээ. Байцаагч нарт бичигдээгүй үлдэгдэл тасалбар нь санхүүгийн тайланд тусгагдахгүй орхигдсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т заасантай нийцэхгүй байна. Мөн хагас жилээр болон жилийн эцэст үнэт цаасны тооллогыг хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион

байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” гэж заасныг зөрчиж байна.Цаашид байцаагч нарт өгч буй БМТТХ тасалбарыг үнэт цаасны бүртгэлээр дамжуулан бичилт хийж, байцаагч нараас бичигдсэн тасалбарын тоогоор бараа материалын товчоо тайланд тусгаж байх хэрэгтэй. Аймгийн ЗДТГ-ын хүсэлтийн дагуу 2012-2016 оны санхүүгийн тайлан болон анхан шатны баримтад шалгалт хийж 171 акт тогтоосон байна. Тус хяналт шалгалтын актуудыг түүвэрлэн үзэхэд бусдад олгосон, шилжүүлсэн орлогод татвар ногдуулж суутгасан, бусдад олгосон хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод татвар ногдуулж суутган авч төсөвт төлөөгүй, баримтаар нотлогдоогүй зардлыг татвар ногдох орлогоос хасагдах зардалд бичсэн, хувиараа бараа материал бэлтгэж борлуулсны орлогоос татвар төлөөгүй гэх зэрэг зөрчилд 381.5 сая төгрөгийн акт бичигдсэн байна.

3.3 ТЕГ-ын дотоод хяналтын газраас тус хэлтсийн 2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг гүйцэтгэлээр баталгаажуулж, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилт, ТЕГ-ын даргын 2017 оны тушаал, заавар, албан даалгаврын биелэлт, 2016 онд батлагдсан чиг үүргийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүнтэй танилцан дүгнэлт гаргаж, зөвлөмж өгчээ. Уг шалгалтаар 2017 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, гүйцэтгэлээр 85.44 хувь буюу “В” үнэлэгдсэн байна. Нийт 24 үзүүлэлтээс татвар төлөгчдийг бүртгэлд хамруулсан байдал 56,69, татварт хамруулсан байдал 68.32, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжүүлсэн өрийн барагдуулалт 47.85, өмнөх оны тайлангаар ногдуулсан өрийн барагдуулалт 62.56, тайлант оны ногдуулалтын барагдуулалт 69.59 хувиар бусад үзүүлэлт 70.72 хувиас дээш үнэлэгдсэн байна. Мөн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх агентлагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр тус хэлтэс 81.75 хувиар дүгнэгджээ.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2018 оны 04 дүгээр сард Татварын хэлтсийн 2016, 2017 оны татвар ногдуулалт, орлого бүрдүүлэлт болон санхүүгийн үйл ажиллагааны шалгалт хийж холбогдох хуулиуд, хууль эрх зүйн актын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, заавар, зөвлөмж өгч ажиллажээ. Шалгалтаар 1,273.1 мянган төгрөгийн улсын байцаагчийн төлбөрийн акт тогтоож, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэжээ. Татвар төлөгчдийг бүртгэлд хамруулсан байдал нь дээрх шалгалтуудад хамрагдаж ТЕГ-ын дотоод хяналт шалгалтаар татвар төлөгч ААНБ, иргэний тоо бодитой биш байгаа нь тогтоогдож хөрөнгийг бүртгэж гэрчилгээ олгодог төрийн байгууллагуудтай мэдээлэл харилцан солилцох, хамтарч ажиллах ажиллагааг сайжруулах, бүртгэлийн зөрүүг залруулах талаар зөвлөмж өгчээ. Иймд татвар төлөгчдийн бүртгэлд хамруулсан байдлыг гүйцэтгэлийн аудитад хамруулаагүй болно.

ХОЁР. АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Татварын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.
2. Татварын орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөөцийг бүрэн ашиглахгүй байна.
3. Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээлэл цуглуулалт сайн боловч түүний ашиглалт, үр дүн, үр өгөөж хангалтгүй байна.
4. Хэлтсийн даргын тушаалаар баталгаажуулсан жилийн эцсийн татварын өр, ТБМНС-д бүртгэлтэй өр хооронд зөрүү үүссэн, дотоод хяналт шалгалтаар ногдуулсан татварын өрийн барагдуулалт муу байна.

ГУРАВ. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн Татварын хэлтсийн дарга Ж.Баяр-Одод дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

1. Санхүүгийн үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, Сангийн сайдын 2017 оны 36 дугаар тушаалаар төсөвт байгууллагын төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагч нарт төрийн албан хаагчийн албан тушаалын зэрэглэл, шатлалыг ахиулахыг 2019 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэл зогсоох үүрэг чиглэл өгснийг мөрдөж ажиллах.
2. Татварын орлогыг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэл, өрийн үлдэгдэл, тухайн оны татварын ногдуулалтыг үндэслэн нэмэгдүүлж төлөвлөх.
3. Татвар төлөгчийн талаарх хөндлөнгийн мэдээллийг бүртгэх, боловсруулах, ашиглах үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн үнэн зөв байдлыг хангаж ажиллах
4. Бэлэн мөнгөний татвар, торгуулийн хуудсыг байцаагч нарт олгохдоо бүртгэлээр дамжуулан бичилт хийж, байцаагч нараас бичигдсэн тасалбарын тоогоор бараа материалын зарлагын тайланд тусгаж байх.

Аймгийн Татварын хэлтсийн үйл ажиллагаа, үр дүнд хийсэн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
